Тайлант онд 1,467,043.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 96.0 хувь буюу 1,411,839.2 мянган төгрөгийг хөрөнгийн хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна. Үүнд ЗДТГ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 53,900.0 мянган төгрөгийн худаг, уул уурхайн хандиваар 43,072.6 мянга, Соёлын төв нь

улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,198,900.0 мянган төгрөгийн барилга, уул уурхайн хандиваар 17,167.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж, ЕБС нь өмнөх оны авлагыг барагдуулж 9,950.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 41,888.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, Эрүүл мэндийн төв нь 23,813.4 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн Эрүүл мэндийн газраас болон бусад байгууллагаас, Цэцэрлэг нь 2,148.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	4,479,185.2	4,597,317.6	118,132.4	47.2
ЗДТГ	9,635.0	11,615.0	1,980.0	0.1
Соёл	267,106.4	1,505,473.6	1,238,367.2	15.4
ЕБС	1,864,265.9	1,939,066.9	74,801.0	19.9
Цэцэрлэг	855,778.6	859,926.6	4,148.0	8.8
Эмнэлэг	803,668.4	832,843.7	29,175.3	8.5
СХСан		440.0	440.0	0.0
НИЙТ ДҮН	8,279,639.4	9,746,683.4	1,467,043.9	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 55,204.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 43,036.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 1,265,830.6 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байдлаар 101,972.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	1,467,043.93	Хасагдсан	0.00
Худалдан авсан	55,204.76	Худалдсан	
Хандиваар	44,036.00	Акталсан	0.00
Шилжүүлэн авсан	101,972.58	Шилжүүлсэн	
бусад	1,265,830.59	Бусад	

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 14,427.2 мянга, эцсийн үлдэгдэл 5,736.5 мянган төгрөг болж 8,690.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	14,427.2	5,736.5	8,690.7	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	8,451.1	5,522.3	(2,928.8)	96.3
Байгууллагад төлөх өглөг	5,976.2	214.3	(5,761.9)	3.7
Дүн	14,427.2	5,736.5	(8,690.7)	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 5,736.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЭМД-ын санхүүжилт дутуу орсонтой холбоотой сумын Эрүүл мэндийн төвийн өглөг 5,459.3 мянган төгрөг буюу 95.2 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	1,017.8	200.0	(817.8)	3.5
ЗДТГ	609.8	12.5	(597.3)	0.2
Соёлын төв		28.6		0.5
ЕБС	39.9	34.7	(5.2)	0.6
ЭМТ	12,758.3	5,459.3	(7,299.0)	95.2
Цэцэрлэг	1.4	1.4	-	0.0
ДҮН	14,427.2	5,736.5	(8,719.3)	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,022,506.3 мянга, эцсийн үлдэгдэл 8,407,192.3 мянган төгрөг болж, 1,384,686.0 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,422,292.4	2,422,292.4	-	28.8
Өмч: - төрийн	2,422,292.4	2,422,292.4	-	28.8
Хуримтлагдсан үр дүн	2,807,112.9	4,191,798.9	1,384,686.0	49.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,793,101.1	1,793,101.1	-	21.3
Дүн	7,022,506.3	8,407,192.3	1,384,686.0	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн данс 1,384,686.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,384,686.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн хуралдаанаар 11 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 117,700.0 мянга, хүү торгуулийн орлогыг 5,000.0 мянга, нийт 122,700.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	117,700.0	179,665.3	61,965.3	152.6
ИОТХ	15,500.0	26,976.6	11,476.6	174.0
Бууны татвар	1,200.0	1,198.3	(1.7)	99.9
Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	1,692.8	192.8	112.9
Хадгаламжийн хүүгийн орлого	50,000.0	43,907.2	(6,092.8)	87.8
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.0	850.0	(2,150.0)	28.3
Газрын төлбөр	40,000.0	93,620.3	53,620.3	234.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0	11,120.0	5,120.0	185.3
бусад татвар	500.0	300.0	(200.0)	60.0
2.Татварын бус орлого	5,000.0	9,495.0	4,495.0	189.9
2.1.Хүү торгуулийн орлого	5,000.0	9,495.0	4,495.0	189.9
Нийт дүн	122,700.0	189,160.3	66,460.3	154.4

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 61,965.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 11,476.6 мянга, улсын тэмдэгтийн хураамж 192.8 мянга, газрын төлбөр 53,620.3 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 5,120.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин бууны албан татвар 99.9 хувь буюу 1.7 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 87.8 хувь буюу 6,092.8 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 28.3 хувь буюу 2,150.0 мянга, бусад татвар 60 хувь буюу 200.0 мянган төгрөгийн орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 10.0 мянга, Соёлын төв 6,000.0 мянган төгрөгийн орлогоос 3,100.0 мянган төгрөгийн орлого тус тус орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 56,831.5 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 68,591.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,363,265.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,164,614.7 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 1,955,919.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 208,695.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ний өдрийн 11 дугаар тогтоолоор нийт 2,327,275.2 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	88,295.5	65,864.5	22,431.0
Засаг даргын Тамгын газар	401,584.1	373,453.8	28,130.3
Сургууль	909,262.2	691,393.9	217,868.3
Цэцэрлэг	292,730.5	292,730.5	0.0
Эрүүл мэндийн төв		447,539.5	-447,539.5
Соёлын төв	122,845.7	98,804.4	24,041.3
Сум хөгжүүлэх сан		79,667.6	-79,667.6
Орон нутгийн хөгжлийн сан		277,821.0	-277,821.0
Нийт дүн	1,814,718.0	2,327,275.2	-512,557.2

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор анх 2,327,275.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.29-ний өдрийн 19 дугаар тогтоолоор 27,306.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 8,684.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,363,265.9 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,270,470.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 228,821.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 545,538.7 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 122,700.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 63,831.5 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 24,773.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 107,130.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 8,199.7 мянган төгрөгөөр дутуу, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 8,769.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 34,326.6 мянга, орон нутгийн төсөвт 19,471.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улс	ОН
Засаг даргын Тамгын газар	421,277.9	406,995.7	14,282.2	96.6	-	13,292.2
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	68,423.0	66,958.4	1,464.6	97.9	-	1,464.6
Соёлын төв	101,414.7	93,799.8	7,614.9	92.5	-	4,714.9
Сум хөгжүүлэх сан	79,667.6	711.4	78,956.2	0.9	-	-
Сургууль	740,893.4	731,986.2	8,907.2	98.8	7,483.3	-
Цэцэрлэг	246,596.1	219,678.0	26,918.1	89.1	24,577.5	-
Эрүүл мэндийн төв	451,261.1	435,790.3	15,470.8	96.6	2,265.8	-
Орон нутгийн хөгжлийн сан	253,732.1	208,695.0	45,037.1	82.3	-	-
Нийт дүн	2,363,265.9	2,164,614.7	198,651.2	91.6	34,326.6	19,471.8

Эх сурвалж: Шинэжинст сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 55,437.3 мянга, сум хөгжүүлэх сангийн зардлыг зээл олгоогүйтэй холбоотой 82,488.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 192,072.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 22,977.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн

ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 166,831.2 мянган төгрөгийг зарцуулж 2,263.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЭДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИИТ
НИИТ ОРЛОГО	1,000.00	14,686.14	19,999.94	9,227.74	147,158.95	192,072.77
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.00	14,686.14	19,999.94	9,227.74	147,158.95	192,072.77
НИИТ ЗАРЛАГА	1,000.00	12,422.50	19,999.87	9,227.74	147,158.95	189,809.06
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000.00	12,422.50	6,249.80		147,158.95	166,831.25
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			13,750.07	9,227.74		22,977.81
Төсөвт төвлөрүүлсэн	0.00	2,263.64	0.07	0.00	0.00	2,263.71

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 35,000.0 төгрөгөөр тодотгон баталж 34,927.2 мянган төгрөгийг зарцуулж 72.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 67.7 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал, малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 86.6 хувийг, 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд 2.9 хувийг, 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт 10.5 хувийг тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 86.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,363,265.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,164,614.7 мянган төгрөгийг зарцуулж, 91.5 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 9 нэр төрлийн орлогоор 122,700.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 189,160.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 154.2 хувь буюу 66,460.3 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 4 нэр төрлийн орлого 8,544.5 мянган төгрөгөөр төлөвлөснөөс тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Шинэжинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Төрийн аудитын байгууллагаас Шинэжинст сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Зөрчилгүй	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан			Хязгаарла лттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЕБСургууль	1	1	1		1	1				
Хүүхдийн цэцэрлэг	1	1	1		1	1				
ЗДТГ	1	1	1		1		1			
ИТХурал	1	1		1						
Соёлын төв	1	1		1						
ЭМТ	1	1	1		1	1				
ОНХС	1	1		1						
СХС	1	1		1						
НИЙТ ДҮН	8	8	4	4	4	3	1	0	0	0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагууд 3 байгууллага зөрчилгүй, 1 байгууллага "Хязгаарлалттай" санал дүгнэлтийг өгсөн байна.

Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021.12.14-ний өдрийн А/32 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсэг томилогдож эд хөрөнгийг тоолсон ба тооллогын комисс нь тооллого хийсэн тухай тэмдэглэл үйлдэж өмч хамгаалах зөвлөлд хүргүүлээгүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 718,904.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 69,968.9 сая төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 134,956.9 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 8,994.1 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 504,984.7 мянган төгрөгийн 16 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ЕБСургууль	5	8,034.2	1	77.1	1	470.1			3	7,487.0
Хүүхдийн цэцэрлэг	0	-								
ЗДТГ	4	7,420.0			2	1,420.0	1.0	-	1	6,000.0
ОНХСан	0	-								
ЭМТ	3	7,573.4			2	7,104.0			1	469.4
СХС	2	68,663.2	1	68,591.8					1	71.4
Соёлын төв	4	14,894.8	1	1,300.0			1	5,000.0	2	8,594.8

СТА зөрчлийн дүн	18	106,585.6	3	69,968.9	5	8,994.1	2	5,000	8	22,622.6
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЕБСургууль	1	-							1	-
Хүүхдийн цэцэрлэг	2	133,506.2					1	129,956.9	1	3,549.3
ЗДТГ	1	92,839.3							1	92,839.3
ОНХСан	1	86,195.0							1	86,195.0
ИТХурал	0	-								
СХС	1	27,000.0							1	27,000.0
Соёлын төв	2	24,817.5							2	24,817.5
ЭМТ	1	247,961.0							1	247,961.0
Нийцлийн аудитын дүн	9	612,319.0	0	0	0	0	1	129956.9	8	482,362.1
Нийт дүн	27	718,904.5	3	69,968.8	5	8,994.1	3	134,956.9	16	504,984.7

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 106,585.6 мянган төгрөгийн 18 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 612,319.0 мянган төгрөгийн 9 зөрчил тус тус илэрсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 129 мэдээллээс 87 мэдээллийг хугацаанд нь, 40 мэдээллийг хоцроож, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	10	10	6	2	2
2	Хагас жил	3	3	2	1	
3	Улирал бүр	2	8	5	3	
4	Сар бүр	3	36	43	17	
5	Тухай бүр	6	72	49	23	
	Нийт	24	129	87	40	2

Эх сурвалж. Шинэжинст сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Шинэжинст сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шинэжинст сумын ЕБС нь бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,193.0 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан, тогтмол зардалд 92,930.9 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 98.5 хувь буюу 91,513.8 мянган төгрөгийг зарцуулан Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,443.9 мянган төгрөгөөр баталж, тодотголоор 3,278.2 мянган төгрөгөөр бууруулан 19,165.7 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 19,165.7 мянган төгрөг зарцуулсан нь тогтмол зардлын 20 хувь бууруулах буюу 3,549.3 мянган төгрөг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 9,293.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн 150 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	4	9,293.8	4	9,293.8			100.0
Нийт	4	9,293.8	4	9,293.8			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд анхаарах асуудал байхгүй. Харин тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 185,700.2 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид авлагын тооцоог тухайн онд багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

4. Аудитын илрүүлэлт

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 8,909.7 мянган төгрөгийн зөрчил илэрч 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж байна.

4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх.

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор анх 2,327,275.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.29-ний өдрийн 19 дугаар тогтоолоор 27,306.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар ЕБС-ийг 4,784.0 мянга, хүүхдийн цэцэрлэгийн 3,900.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,363,265.9 мянган төгрөг болжээ

Харин Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 8,684.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх.

3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 718,904.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж, нягтлан бодогч нарын ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах

4. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 129 мэдээллээс 87 мэдээллийг хугацаанд нь, 40 мэдээллийг хоцроож, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

5. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой.

Илрүүлэлт Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 189,160.3 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 188,934.6 мянган төгрөг буюу 225.7 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын санхүүгийн албаны дарга татварын байцаагчтай тооцоо нийлж аймгийн Татварын хэлтэст татварын мэдээг үнэн зөв мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Хавсралт 1. Шинэжинст сумын Засаг даргын нэгтгэсэн тайлангийн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Шинэжинст сумын Засаг даргын 2021О оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
2022			БНА-2022/17/СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Шинэжинст сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
	1	2	3	Албан тушаал	Овог нэр
	1				
	Шинэжинст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд				
1	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.		Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Х.Дагважав
2	Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 8,684.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.	8,684.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Х.Дагважав
3	Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 726,008.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хэрэгжүүлж ажиллаагүй байна.		Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Х.Дагважав
4	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 106 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.		Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Х.Дагважав
5	Тус сумын ОНХО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 189160.3 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 188934.6 мянган төгрөг буюу 225.7 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.	225.7	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ Х.Дагважав
ДҮН		8,909.7			

оОо

5.Хавсралт 2. Шинэжинст сумын Засаг даргын харьяа байгууллагуудын алдаа зөрчлийн жагсаалт

/мянган төгрөгөөр/					
Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа зөрчлийн шийдвэрлэлт	Алдаа зөрчилтэй асуудал харгасан албан тушаалтны нэр	Албан тушаалын зөвөлгөө
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		100,259.3			
1	ЗДТГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 14 ний А/31 тоот тушаалаар тэмцээнд оролцох баг тамирчдад нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,000.0 төгрөгөөр тоглолтын хувцас хийлгэж олгосон байна.	1,000.00	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
2	Цалингаас дундын суутгал 420.0 мянган төгрөгийг суутгалгүй төсвөөс илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.	420.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
3	Сумын ЗДТГ-ын 2021.12.14-ний өдрийн А/32 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсэг томилогдож эд хөрөнгийг тоолсон ба тооллогын комисс нь тооллого хийсэн тухай тэмдэглэл үйлдэж өмч хамгаалах зөвлөлд хүргүүлээгүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	-	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
4	Сумын хот тохижилт үйлчилгээний алба ОНӨААН-ийн дансанд хог хаягдлын зардалд сар бүр 500.0 мянган төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу нийт 6,000.0 мянган төгрөгийг тус байгууллагатай гэрээ байгуулаагүй ямар үйлчилгээ авсан нь тодорхойгүй байхад шилжүүлсэн байна.	6,000.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
5	Тус байгууллага нь 2021 онд нийт 458,091.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 56,908.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 мөнгөн гүйлгээний 35,930.4 мянган төгрөгийг мэдээлээгүй байна	92,839.3	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
Ерөнхий боловсролын сургууль		8,034.2			
1	Сургуулийн захирал Ш.Даваацэрэнд Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2021.05.19-ний өдрийн 05-03-009/11 дугаар актаар тус оны 03 дугаар сард хоолны хордлого болж эмчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн эмчилгээ, хоол, шатахууны 821,3 мянган төгрөгийн зардлыг төлүүлэх акт тогтоосон байхад төсвөөс 2021.06.22-ний өдөр 432.6 мянган төгрөгийг төлсөн, төсвийн хөрөнгөөр 37.5 мянган төгрөгийн хадаг худалдан авсан байна.	470.1	төлбөрийн акт	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Даваацэцэн, Х.Гантулга
2	Сумын төрийн сангийн төлөөлөгч 2021.03.31-ний өдөр "Жаргалант энхмөнх" ХХК-д 571.0 мянган төгрөгийн эмийн үнийн эмийн зардлаас шилжүүлэх гүйлгээг дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас шилжүүлснээс тухайн зардлууд буруу илэрхийлэгдсэн байна.	77.1	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Даваацэцэн, Х.Гантулга
3	2021 оны 9 дүгээр сард 3,160.5 мянган төгрөгийн эм боох материалыг 11 ширхэг шаардах хуудсаар олгохдоо байгууллагын даргаар цохолт хийлгээгүй, нярвын бэлтгэсэн тайланг нягтлан бодогч хянаагүй байна.	3,160.5	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Даваацэцэн, Х.Гантулга
4	Байгууллагын албан хаагчдад төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,543.5 мянган төгрөгийн бараа материалыг олгосон анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	3,543.5	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Даваацэцэн, Х.Гантулга

	Сургуулийн эмч 783.0 мянган төгрөгийн ковидын төстийн бүртгэлийг бүрэн хөтлөөгүй байна.	783.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Даваацэцэн, Х.Гантулга
	Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,193.0 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан, тогтмол зардалд 92,930.9 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 98.5 хувь буюу 91,513.8 мянган төгрөгийг зарцуулан Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Даваацэцэн, Х.Гантулга
Соёлын төв		39,712.3			
1	Өмнөх онуудад авсан номыг нэр төрлөөр аваагүй, ашиглах жилийн -1 жилээр оруулсан байна.	8,594.8	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Мөнх-Эрдэнэ С.Хишигтогтох
2	Бүртгэлээр тавих хяналт сул, бараа материалын тайлан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Мөнх-Эрдэнэ С.Хишигтогтох
3	"АИЕТИЮНИПИКЭШН" ХХК-д 2021.12.13-нд зөврийн компьютер, принтерийн үнэнд 5,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байхад хөрөнгийг орлогод аваагүй байна.	5,000.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Мөнх-Эрдэнэ С.Хишигтогтох
4	Тайлант онд үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг 1,300.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.	1,300.0	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Мөнх-Эрдэнэ С.Хишигтогтох
5	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,000.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 18,532.5 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээг орхигдуулсан байна.	23,532.5	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Мөнх-Эрдэнэ С.Хишигтогтох
6	"Зах гурван бамбуу" ХХК-аас 2021.12.13-ний өдөр 1,285.0 мянган төгрөгийг шилжүүлж, холбооны хэрэгсэл авахдаа шууд зардлаар бүртгэсэн, нийлүүлэгч байгууллагын зарлагын падаан байхгүйгээс ямар хөрөнгө авсан нь тодорхой бус байна.	1,285.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ш.Мөнх-Эрдэнэ С.Хишигтогтох
Сум хөгжүүлэх сан		95,663.2			
1	Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш 27,000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	27,000.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ С.Хишигтогтох
	Өмнөх онд өглөггүй байхад 2021 оны 6 дугаар сард 71.4 мянган төгрөгийг нэр данс зөрүүтэй гэж шилжүүлсэн байна.	71.4	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ С.Хишигтогтох
	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүүгийн авлагыг зөрүүтэй тусгасан.	68,591.8	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ С.Хишигтогтох
Орон нутгийн хөгжлийн сан		86,195.0			
1	Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 т заасан 86195.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хоцроосон	86,195.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ С.Хишигтогтох
Эрүүл мэндийн төв		255,534.4			
1	Шилэн дансны цахим системд нийт төрлийн 435,790.7 мянган төгрөгийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 247,961.0 мянган төгрөгийн 73 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	247,961.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Энхбаяр Н.Нямдорж
2	НДШ-н 3,299.8 мянган төгрөгийн шимтгэлийг суутган тооцоогүй, НДШ-ийн мэдээнд мэдээлээгүй, санхүүгийн тайланд 3,586.7 мянган төгрөгийг НДШ-ийн өглөгөөр бүртгээгүй байна.	6,886.60	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Энхбаяр Н.Нямдорж
3	Цалингаа суутгасан ҮЭ-ийн татварыг төсвөөс шилжүүлэхдээ 217.4 мянган төгрөгийг илүү шилжүүлэн авлагаар бүртгэсэн байна	217.4	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Энхбаяр Н.Нямдорж
4	өмнөх онд гарсан зөрчлийг арилгаагүй эмийн авлага 469.4 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.	469.4	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Энхбаяр Н.Нямдорж

Шинэжинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүүхдийн цэцэрлэг		133,506.2			
1	Шилэн дансны цахим системд нийт 17 төрлийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлхээс 129,956.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроожмэдээлсэн байна	129,956.9	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Оюунчимэг Х.Гантулга
2	Тогтмол зардлыг 3,549.3 мянган төгрөгөөр хэмнээгүй нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.	3,549.3	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Оюунчимэг Х.Гантулга
Нийт дүн		718,904.5			